

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төрийн худалдан авах ажиллагааны газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/170/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Ахлах аудитор: А.Даваадорж Утас: 261628 Цахим хаяг: davaadorja@audit.gov.mn Аудитор: Я.Марал-Эрдэнэ Утас: 261628 Цахим хаяг: maral-erdeneya@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
ДАРГА Ц.БАТЗУЛ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.20 № 07/591
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төрийн худалдан авах ажиллагааны газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Нэмэлт санхүүжилтийн дансаар 723,113.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 95,750.0 мянган төгрөгийг тоног төхөөрөмж, 19,794.0 мянган төгрөгийг тавилга, эд хогшил худалдан авах зардалд, 67,347.2 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ, 206,258.7 мянган төгрөгийг нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардалд тус тус зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 316, 800 дугаар “Үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай” тогтоолуудын дагуу нийт 97,206.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг нэмж бүртгэсэн, “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай” 747 дугаар

тогтоолын дагуу нийт 461,697.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоосон, "Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай" 816 дугаар тогтоолын дагуу нийт 100,212.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хассан "Үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай", 749 дүгээр тогтоолын дагуу нийт 11,521.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлэгт шилжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2,202,615.5 мянган төгрөгийн 196 төсөл, арга хэмжээний 312 багц, он дамжин хэрэгжих 140,155,800.0 мянган төгрөгийн 18 төсөл, арга хэмжээний 21 багц, эрх шилжсэн 323,953,940.0 мянган төгрөгийн 53 төсөл, арга хэмжээний 96 багц, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжих 371,545,800.0 мянган төгрөгийн 7 төсөл, арга хэмжээний 10 багц тендер шалгаруулалтыг тус тус зохион байгуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	10,615,980.00	8,490,750.00
35	БАРАА МАТЕРИАЛ	10,615,980.00	8,490,750.00
354	Хангамжийн материал	10,615,980.00	8,490,750.00
35410	Бичиг хэргийн материал	9,936,980.00	5,998,300.00
35460	Хүнсний материал	679,000.00	2,492,450.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,125,600,057.43	2,388,371,985.95
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,125,600,057.43	2,388,371,985.95
392	Биет хөрөнгө	652,325,297.43	920,709,709.96
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,273,667,767.14	1,095,439,904.89
39206	Хуримтлагдсан элэгдэл	(676,574,907.14)	(263,305,059.94)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	128,334,784.50	213,304,698.35
39208	Хуримтлагдсан элэгдэл	(73,102,347.07)	(124,729,833.34)
393	Биет бус хөрөнгө	1,473,274,760.00	1,467,662,276.00
39301	Програм хангамж	27,062,760.00	21,450,276.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1,446,212,000.00	1,446,212,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,136,216,037.43	2,396,862,735.96
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,136,216,037.43	2,396,862,735.96
51	Засгийн газрын хувь оролцоо	2,136,216,037.43	2,396,862,735.96
512	Хуримтлагдсан үр дүн	2,136,216,037.43	2,396,862,735.96
51210	Өмнөх үеийн үр дүн	2,136,216,037.43	2,136,216,037.43
51220	Тайлант үеийн үр дүн	-	260,646,698.53
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,136,216,037.43	2,396,862,735.96

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2,568,290,488.17	3,133,513,361.66
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	463,413,816.45	505,199,063.16
120	Нийтлэг татварын бус орлого	463,413,816.45	505,199,063.16
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	463,413,816.45	505,061,946.86
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	356,720,906.45	480,061,946.86
120009	Бусад орлого	-	137,116.30
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,104,876,671.72	2,628,314,298.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,407,418,800.00	1,905,201,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,407,418,800.00	1,905,201,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	697,457,871.72	723,113,098.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	697,457,871.72	723,113,098.50
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,280,576,200.87	2,846,684,089.08

Төрийн худалдан авах ажиллагааны газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,280,576,200.87	2,846,684,089.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,592,419,356.40	2,102,112,011.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	884,544,557.09	1,246,370,392.53
210101	Үндсэн цалин	537,024,680.12	797,971,373.19
210102	Нэмэгдэл	156,207,084.81	184,086,367.86
210103	Унаа хоолны хөнгөлөлт	120,596,273.30	158,320,524.21
210104	Урамшуулал	70,716,518.86	105,992,127.27
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	114,367,622.79	161,088,273.95
210201	Тэтгэврийн даатгал	78,358,851.51	110,878,283.33
210202	Тэтгэмжийн даатгал	9,212,717.79	13,044,503.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,145,654.21	6,538,835.18
210204	Ажилгүйдлийн даатгал	1,786,563.58	6,125,330.34
210205	Эрүүл мэндийн даатгал	17,863,835.70	24,501,321.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	165,899,990.00	162,802,300.00
210304	Байрны түрээс	165,899,990.00	162,802,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,468,225.37	37,338,324.36
210401	Бичиг хэрэг	2,892,010.00	10,452,060.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,836,715.37	25,912,264.36
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	739,500.00	974,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	62,105,602.00	166,161,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,405,560.00	160,393,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	69,776.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	27,630,266.00	5,768,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	354,033,359.15	328,351,720.28
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	80,000.00	250,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	353,953,359.15	328,101,720.28
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	688,156,844.47	744,572,077.96
2132	Бусад урсгал шилжүүлэг	198,421,500.00	212,358,724.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	6,100,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,721,500.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	167,700,000.00	206,258,724.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	489,735,344.47	532,213,353.96
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	489,735,344.47	532,213,353.96
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	287,714,287.30	289,469,048.62
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	26,182,574.05
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	26,182,574.05
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	-	(26,182,574.05)
V	НИЙТ ҮР ДҮН	287,714,287.30	260,646,698.53

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,211,569,581.72	2,653,451,414.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	106,692,910.00	25,137,116.30
120	Нийтлэг татварын бус орлого	106,692,910.00	25,137,116.30
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	106,692,910.00	25,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	106,692,910.00	25,000,000.00
120009	Бусад орлого	-	137,116.30
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,104,876,671.72	2,628,314,298.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,407,418,800.00	1,905,201,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,407,418,800.00	1,905,201,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	697,457,871.72	723,113,098.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	697,457,871.72	723,113,098.50
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,930,226,921.72	2,516,457,138.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,930,226,921.72	2,516,457,138.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,242,070,077.25	1,771,885,060.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	884,544,557.09	1,246,370,392.53
210101	Үндсэн цалин	537,024,680.12	797,971,373.19
210102	Нэмэгдэл	156,207,084.81	184,086,367.86
210103	Унаа хоолны хөнгөлөлт	120,596,273.30	158,320,524.21
210104	Урамшуулал	70,716,518.86	105,992,127.27
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	114,367,622.79	161,088,273.95
210201	Тэтгэврийн даатгал	78,358,851.51	110,878,283.33
210202	Тэтгэмжийн даатгал	9,212,717.79	13,044,503.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,145,654.21	6,538,835.18
210204	Ажилгүйдлийн даатгал	1,786,563.58	6,125,330.34
210205	Эрүүл мэндийн даатгал	17,863,835.70	24,501,321.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	165,899,990.00	162,802,300.00
210304	Байрны түрээс	165,899,990.00	162,802,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,072,305.37	35,213,094.36
210401	Бичиг хэрэг	6,820,590.00	6,513,380.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,836,715.37	25,912,264.36
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	415,000.00	2,787,450.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	62,105,602.00	166,161,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,405,560.00	160,393,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	69,776.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	27,630,266.00	5,768,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	80,000.00	250,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	80,000.00	250,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	688,156,844.47	744,572,077.96
2132	Бусад урсгал шилжүүлэг	198,421,500.00	212,358,724.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	6,100,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,721,500.00	-

Төрийн худалдан авах ажиллагааны газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	167,700,000.00	206,258,724.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	489,735,344.47	532,213,353.96
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	489,735,344.47	532,213,353.96
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	281,342,660.00	136,994,276.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	281,342,660.00	136,994,276.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	281,342,660.00	136,994,276.00
2200	Дотоод эх үүсвэрээр	281,342,660.00	136,994,276.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	281,342,660.00	136,994,276.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(281,342,660.00)	(136,994,276.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	1,848,501,750.14	1,848,501,750.14
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	1,848,501,750.14	1,848,501,750.14
9	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	287,714,287.30	287,714,287.30
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	2,136,216,037.43	2,136,216,037.43
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	2,136,216,037.43	2,136,216,037.43
19	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	260,646,698.53	260,646,698.53
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	2,396,862,735.96	2,396,862,735.96

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,930,201,200.00	1,732,088,060.84	198,113,139.16	89.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,930,201,200.00	1,732,088,060.84	198,113,139.16	89.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,923,334,200.00	1,725,988,060.84	197,346,139.16	89.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,411,772,700.00	1,246,370,392.53	165,402,307.47	88.3
210101	Үндсэн цалин	826,242,500.00	797,971,373.19	28,271,126.81	96.6
210102	Нэмэгдэл	332,413,200.00	184,086,367.86	148,326,832.14	55.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	192,295,600.00	158,320,524.21	33,975,075.79	82.3
210104	Урамшуулал	60,821,400.00	105,992,127.27	(45,170,727.27)	174.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	190,221,600.00	161,088,273.95	29,133,326.05	84.7
210201	Тэтгэврийн даатгал	129,350,700.00	110,878,283.33	18,472,416.67	85.7
210202	Тэтгэмжийн даатгал	15,217,700.00	13,044,503.94	2,173,196.06	85.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,608,800.00	6,538,835.18	1,069,964.82	85.9
210204	Ажилгүйдлийн даатгал	7,608,900.00	6,125,330.34	1,483,569.66	80.5
210205	Эрүүл мэндийн даатгал	30,435,500.00	24,501,321.16	5,934,178.84	80.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	162,802,300.00	162,802,300.00	-	100.0
210304	Байрны түрээс	162,802,300.00	162,802,300.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	35,277,500.00	35,213,094.36	64,405.64	99.8
210401	Бичиг хэрэг	7,489,900.00	6,513,380.00	976,520.00	87.0
210402	Тээвэр, шатахуун	1,257,500.00	-	1,257,500.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	25,153,700.00	25,912,264.36	(758,564.36)	103.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,376,400.00	2,787,450.00	(1,411,050.00)	202.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	122,896,100.00	120,264,000.00	2,632,100.00	97.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	116,460,900.00	114,496,000.00	1,964,900.00	98.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	459,500.00	-	459,500.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	10,400.00	-	10,400.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	183,800.00	-	183,800.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	13,400.00	-	13,400.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,768,100.00	5,768,000.00	100.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	364,000.00	250,000.00	114,000.00	68.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	364,000.00	250,000.00	114,000.00	68.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,867,000.00	6,100,000.00	767,000.00	88.8

Төрийн худалдан авах ажиллагааны газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2132	Бусад урсгал шилжүүлэг	6,867,000.00	6,100,000.00	767,000.00	88.8
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,867,000.00	6,100,000.00	767,000.00	88.8
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,930,201,200.00	1,732,088,060.84	198,113,139.16	89.7
310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,905,201,200.00	1,706,950,944.54	198,250,255.46	89.6
31001	Улсын төсвөөс санхүүжих	1,905,201,200.00	1,706,950,944.54	198,250,255.46	89.6
20004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	25,000,000.00	25,137,116.30	(137,116.30)	100.5
200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,000,000.00	25,137,116.30	(137,116.30)	100.5
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1	1	-	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	
610001	Төсвийн байгууллага	1	1	-	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	54	38	16	70.4
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	44	29	15	65.9
620003	Үйлчлэх ажилтан	9	8	1	88.9

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		723,113,098.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ		723,113,098.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		182,891,276.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		115,544,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		95,750,000.00
210602	Тавилга		19,794,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		67,347,276.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		45,897,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		21,450,276.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		540,221,822.50
2132	Бусад урсгал шилжүүлэг		206,258,724.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		206,258,724.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		723,113,098.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		723,113,098.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		723,113,098.50

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 334,008.6 мянган төгрөгийн 2 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн улсын төсвөөс олгосон санхүүжилтийг 333,825.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.	1	333,826.0			1	333,826.0	1	333,826.0				
Санхүүгийн байдлын тайлан дахь машин тоног төхөөрөмжийн эцсийн үлдэгдлийн дүнг үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн тоног төхөөрөмжийн эцсийн үлдэгдлийн дүнгээс 182.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан	1	182.6			1	182.6	1	182.6				
Дүн	1	334,008.6			1	334,008.6	1	334,008.6				

Төрийн худалдан авах ажиллагааны газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

3.2 Аудитаар илрүүлсэн 21,200.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлын төсвөөс эдийн засгийн ангилал зөрчин худалдан авах ажиллагаатай холбоотой дотоод сургалтын зардал, заалны түрээсийн зардал гаргасан байна.	1	20,000.0			1	20,000.0
2	Газрын даргын 2024 оны Б/12 дугаар тушаалаар албан хаагчид 1 сарын цалинтай чөлөө буюу 1,200.0 мянган төгрөг, 2 сарын цалингүй чөлөө олгосон байна.	1	1,200.0			1	1,200.0
	Дүн	2	21,200.0	-	-	2	21,200.0

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудиттай холбоотой зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тус газрын даргын А/447 дугаар тушаалын дагуу хуулийн өөрчлөлттэй холбоотой сургалт зохион байгуулахдаа үйл ажиллагааны чиглэл өөр /гадаад худалдаа/ компанитай түрээсийн гэрээ байгуулан 12,300.0 мянган төгрөг шилжүүлсэн байна.	1	-			1	-
2	ТХААГ нь тендер шалгаруулалттай холбоотой баримтаас бусдаар цахим архивын нэгж үүсгээгүй байна.	1	-			1	-
	Дүн	2	-	-	-	2	-